

Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулиудын нэмэлт, өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх ажлын даалгавар

2026 оны 9 дүгээр сар

1. Үндэслэл

Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төсөл УИХ-д өргөн баригдаад байна. Уг хуулийн төсөлтэй хамт 6 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, 1 хууль шинээр батлахаар байна. Иймд УИХ-д өргөн барьснаас хойш 2 сар гаруйхан хугацааны дотор батлагдах хуваарьтай ирэх оны төсвийн тухай хуулийг дагуулж олон тооны хуульд өөрчлөлт оруулахаар байгаа нь зохистой эсэх асуудлаар ННФ-ын зүгээс хэлэлцүүлэг хийхээр төлөвлөж байгаа юм. Эдгээр дагалдах хуулиудын нэмэлт, өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх зөвлөх үйлчилгээ авах шаардлагатай байна.

2. Судалгааны ажлын зорилго

Энэхүү дүн шинжилгээ нь Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулиудад дүн шинжилгээ хийж, асуудал дэвшүүлэх зорилготой.

3. Гүйцэтгэх ажил

2027 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Засгийн газраас дараах 6 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар УИХ- өргөн барьжээ. Үүнд:

- i. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль
- ii. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- iii. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- iv. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль
- v. Төсвийн тухай хууль
- vi. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль тус тус болно.

Түүнчлэн Нийгмийн болон суурь дэд бүтцийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тухай хуулийг шинээр боловсруулан өргөн барьжээ.

Зөвлөх нь Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн дээрх 6 хуулийн нэмэлт, өөрчлөлт, шинээр өргөн барьсан 1 хуульд дараах хүрээнд дүн шинжилгээ хийж, түүнийгээ хэлэлцүүлэг, уулзалтад танилцуулах ажил гүйцэтгэнэ. Үүнд:

- i. Хуулиудад орох гол өөрчлөлтөд дүгнэлт хийх
- ii. Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд: Хууль шинээр боловсруулан өргөн барих, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад хамаарах зохицуулалтын нийцлийг Төсвийн тухай хуулийн болон дагах хуулийн агуулгыг харьцуулах замаар шалган дүгнэлт бичих;
- iii. Үр дагавар ба бусад асуудлын нийцлийн хүрээнд татварын хуульд суурилсан нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төслүүд өргөн барих шаардлагатай эсэхэд дүгнэлт өгөх;
- iv. Дээрхээс гадна бусад анхаарах асуудал байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх.

4. Зорилтот хэрэглэгчид

Судалгааны дүнгийн зорилтот хэрэглэгчид нь бодлого боловсруулагчид болон олон нийт, иргэний нийгэм байна.

5. Хүлээлгэж өгөх бүтээгдэхүүн:

Ажил гүйцэтгэгч нь дараах бүтээгдэхүүнүүдийг хуваарьт заасны дагуу ННФ-д хүлээлгэж өгнө. Үүнд:

	Бүтээгдэхүүн	Хугацаа
1	Дүн шинжилгээний эхний тайланг ННФ-д ирүүлэх	2026 оны 10-р сарын 14-ний дотор
2	Судалгааны дүнг нийтэд танилцуулах	2026 оны 10-р сарын 22-ны дотор
3	Дүн шинжилгээний эцсийн тайланг ННФ-д ирүүлэх	2026 оны 10-р сарын 25-ны дотор

6. Мэдээллийн эх сурвалж

Судалгааг хийхдээ дор дурдсан болон бусад холбогдох баримт бичгүүдийг ашиглана. Үүнд:

- Монгол Улсын 2027 оны төсвийн төслийн баримт бичиг (дэлгэрэнгүй танилцуулга, дагалдах хуулиуд, тооцоолол)
- Төсвийн мэдээллийн холбогдох цахим хуудаснууд
- Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын холбогдох хууль, тогтоомжууд
- Холбогдох төрийн байгууллагууд
- Бусад эх сурвалжууд

7. Ажил гүйцэтгэх хугацаа, төсөв

Ажлын удирдамжийн 3-р зүйлд заасан ажлуудыг 2026 оны 10-р сарын 1-нээс 25-ны хооронд гүйцэтгэнэ.

Судалгааны ажлын төсөв:

Судалгааны хүрээнээс хамаарч судалгааны төсвийн дээд хязгаар 5 сая төгрөг байна.

Зөвлөх нь Нээлттэй нийгэм форумтай нягт хамтран ажиллах ба судалгааны бүтээгдхүүнүүдийг 5-р зүйлд заасан хуваарийн дагуу ирүүлнэ.

8. Судалгааны ажилд тавигдах бусад шаардлага, хэмжээ, хэлбэр

Гэрээт ажилд ашигласан дагалдах материал, судалгааны эх бичвэрийн файл, цахим хуудас зэргийн жагсаалтыг ажлын гүйцэтгэлд хавсаргана.

